



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 12 өдөр


Дугаар А/516

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8, Төсвийн тухай хуулийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолоор батлагдсан "Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журам"-ын 4.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэргийн Гавьяаны Улаан Тугийн одонт Ардын хатанбаатар С.Магсаржавын нэрэмжит Зэвсэгт хүчний 123 дугаар анги үүсэн байгуулагдса ны түүхт 100 жилийн ой энэ онд тохиож, ойн арга хэмжээ 2022 оны 08 дугаар сарын 19-ний өдөр болох тул тус ангийн сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, бие бүрэлдэхүүний ажиллаж амьдрах ая тухтай орчныг хангах зардалд нийт 2,519,800 төгрөгийг хавсралтын дагуу гаргаж зарцуулсугай.
2. Тус арга хэмжээнд шаардагдах 2,519,800 төгрөг (хоёр сая таван зуун арван есөн мянга найман зуу)-ийг цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрөөс гарган зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д зөвшөөрсүгэй.
3. Зарцуулсан төсөв хөрөнгийн талаарх тайлан мэдээ, нэхэмжлэхийг бүрдүүлэн ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Бадрал), Цэргийн штабын дарга хурандаа (Б.Ганхуяг) нарт үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 2534
Zah A/516 tum

Аймгийн Засаг даргын 2022 оны
08 дугаар сарын 12-ны өдрийн
А/516 дугаар захирамжийн хавсралт



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 123 ДУГААР АНГИЙН 100 ЖИЛИЙН ОЙН
АРГА ХЭМЖЭЭНД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Материалын нэр	Тоо нэгж	Мөнгөн дүн	Тайлбар
1	Зөөврийн компьютер /Dell I3/	1	1,939,900	
2	Зурагт /TCL/	1	579,900	
Нийт дүн		2	2,519,800	

-oOo-